

Баянхонгор аймгийн  
АН-ын хорооны тэргүүлэгчдийн  
хурлаар хэлэлцэж батлав.  
2020 оны 7-р сарын 27-ны өдөр

**БАЯНХОНГОР АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН 2020 ОНЫ АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН  
СОНГУУЛИЙН “БҮТЭЭЛЧ БАЯНХОНГОРЧУУД” МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**Хөтөлбөрийн уриа: “Хүн бүрд орлого, өрх бүрд өсөлт”**

**Нэг. Хүртээмжтэй эдийн засгийг дэмжиж, тогтвортой өсөлтийг хангах, үйлдвэржүүлэх бодлого.**

1.1. Баянхонгор аймгийг үйлдвэржүүлэх нэгдсэн бодлого боловсруулж, аймгийн ДНБ-ний үйлдвэрлэлийг жил бүр өсгөж, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээг “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”-ын баримт бичигт заасан хэмжээнд хүргэх.

1.2. Шинжлэх ухааны байгууллага, үйлдвэрлэл эрхлэгч нартай хамтран “Дэвшилтэт технологи, иноваци, судалгаа шинжилгээний бизнес инкубаторын төв” байгуулж, шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн гарааны бизнесийг дэмжиж, мэдлэг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

1.3. “Баянхонгорт үйлдвэрлэв” сүлжээ дэлгүүрийг сум болгонд салбартайгаар байгуулж, Улаанбаатар болон бусад хотуудын худалдааны сүлжээнд холбож, Баянхонгорын бүтээгдэхүүний борлуулалт, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

1.4. Сумдад түүхий эдийн анхан шатны тордолт хийх цэг байгуулахын зэрэгцээ ноос, ноолуур угаах, самнах үйлдвэрийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор хотод байгуулна.

1.5. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн “Хонгор агро парк”-ийг байгуулж, мах, сүү, хүнсний ногооны үйлдвэрлэл, борлуулалтын кластерын сүлжээг бий болгоно.

1.6. Орчин үеийн технологид нийцсэн барилгын /дулаалга, хайрга, хөөсөнцөр/ материалын үйлдвэрийг тохиромжтой бүсэд байгуулах


1.7. Арьс, нэхий, мах, сүү цагаан идээг уламжлалт болон орчин үеийн дэвшилтэт технологиор боловсруулах, үйлдвэрлэх үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.

1.8. Ахуйн үйлчилгээ, оёдлын үйлдвэр хөгжүүлэх санаачилгыг бүх талаар дэмжинэ.

1.9. Аймгийн төвд “хуурай сүүний үйлдвэр” байгуулж, дотоодын хэрэгцээгээ хангахын зэрэгцээ бусад аймаг, хотын зах зээлд нийлүүлнэ.

1.10. Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг боловсруулах хувийн хэвшлийн үйлдвэрлэлийг дэмжиж, хөгжүүлнэ.


1.11. Нийгэм, эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлэх 5 аймгийн нэг болох.

  
• 000000001

/ Манай аймаг 2019 оны өрсөлдөх чадвараараа 21 аймгаас 17-т эрэмбэлэгдэж, нийт 100 оноо авахаас 48,24 оноо авчээ./

### **Хоёр. Хувь хүний хөгжил, эрх чөлөө**

Баянхонгор аймгийн хүний хөгжлийн индексийн үзүүлэлт 2012-2016 онд жил дараалан өсөлттэй байсан бол 2018 оны байдлаар энэ үзүүлэлт 0,651 болж 2015 оныхоос 0,006 пунктээр, улсын дунджаас 0,089 пунктээр тус тус доогуур байна.



#### **2.1. Боловсрол,соёл урлаг**

2.1.1. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, хүүхдэд ээлтэй сургалтын орчинг бүрдүүлэн, сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгож, тэднийг “Баянхонгорын иргэн” болгон төлөвшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.1.2. Багшлах боловсон хүчинд тавих шаардлагыг өндөрсгөж, тэдний мэргэжлийн болон багшлах ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн “Шинэ багш”, “Зочин багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.1.3. Сургууль, эцэг эх, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, боловсролын салбарт хөрөнгө оруулалт хийсэн иргэн, ААН, байгууллагыг бодлогоор дэмжинэ.

2.1.4. Сумдын сургууль цэцэрлэг, соёлын төвүүдийг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр үе шаттай хангаж, сургууль, цэцэрлэгийн удирдлагыг “боловсролын зөвлөл”-ийн саналыг үндэслэн шийдвэрлэж байх бодлого хэрэгжүүлнэ.

2.1.5. Анги дэвших, төгсөх болон хөндлөнгийн шалгалтын үнэлгээгээр хариуцсан ангиа 60-аас дээш хувийн гүйцэтгэлтэй шалгуулсан багш нарыг урамшуулдаг тогтолцоог бий болгоно.

2.1.6. Сургуулийн өмнөх болон бага боловсролын системд хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэх олон талт сургалтыг нэвтрүүлж, хөгжүүлнэ./Баруун тархины хөгжил/

2.1.7. Жил бүр тодорхой тооны залуучуудыг сонгон шалгаруулж, гадаад дотоодын нэр хүндтэй их,дээд сургуулиудын тэтгэлэгт сургалтад хамруулж,гэрээгээр сургана.

2.1.8. Боловсрол, соёл, урлагийн салбарын гадаад харилцааг хөгжүүлж, жил бүр 100 хүртэлх багш, уран бүтээлчид, удирдах ажилтнуудыг гадаадад мэргэжил дээшлүүлэх сургалт, танилцах аялалд хамруулах.

2.1.9. Урлаг, соёлын биет болон биет бус үнэт өвийг хамгаалах, сурталчлах, залуу үедээ уламжлуулан өвлүүлэхийг бодлогоор дэмжинэ.

2.1.10. Малчид, төрийн албан хаагчид, бизнес эрхлэгчдийн “Урлаг спортын наадам”-ыг 2 жилд нэг удаа аймгийн хэмжээнд зохион байгуулах.

#### **2.2. Эрүүл мэнд,спорт**

2.2.1. Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулан, шаардлагатай хүмүүсийг дараагийн шатны үзлэг,оношилгоо, эмчилгээнд хамруулж хэвшинэ.

2.2.2. Хорт хавдраас сэргийлэх зорилтын хүрээнд хавдрын оношилгоо, эмчилгээний хөнгөвчлөх үйлчилгээ үзүүлэх төвийг аймагтаа байгуулж ажиллуулна.

2.2.3. Нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, өрсөлдөх чадвартай уламжлалт анагаах ухааны эмнэлэг байгуулах,хөгжүүлэх санаачилгыг бүх талаар дэмжинэ.



2.2.4. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг сайжруулж, өдрийн болон гэрийн эмчилгээ, асаргаа сувилгаа, сэргээн засах, хөнгөвчлөх үйлчилгээний төрлүүдийг хөгжүүлж, гэрийн эмчийн тогтолцоо руу шилжүүлнэ.

2.2.5. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын мэргэжил, боловсролыг тасралтгүй дээшлүүлэх, резидент сургалтад хамруулах, ур чадварын нэмэгдэл олгох, салбарын удирдлагын менежментийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2.6. Эрүүл мэндийн байгууллагуудыг нэн шаардлагатай орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр эн тэргүүнд хангахын зэрэгцээ өвчтөний оношилгооны баталгаажуулалтыг аймгийн эмнэлэгтээ бүрэн хангаж ажилладаг болно.

2.2.7.Эх, нялхсын эндэгдлийг аймгийн /2016-2025 он/ хөгжлийн бодлогын баримт бичигт заасан түвшинд хүртэл бууруулна..

2.2.8.Эмийн сангуудын менежментийг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн хэлбэрээр хөгжүүлж, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, ханган нийлүүлэлтийг сайжруулж, үнийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ.

2.2.9.“Шинэ зууны эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлж, нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтнуудыг анагаахын өндөр хөгжилтэй орнуудад мэргэжил дээшлүүлж, сургана.

2.2.10. Эрүүл хүнс, эрүүл хооллолтыг бодлогоор дэмжиж, иргэдээ эрүүл хүнсээр хангах асуудлыг үе шаттай төлөвлөж хэрэгжүүлнэ

2.2.11. Нийтийн биеийн тамирыг олны хүртээл болгох, энэ чиглэлээр санаачилга гаргасан иргэн, гэр бүл, сум, баг, байгууллага хамт олныг дэмжих.

2.2.12.Олон улс, дэлхийн чанартай уралдаан тэмцээнд амжилт гаргасан тамирчдыг шагнаж, урамшуулж, алдаршуулна.

### **2.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих**

2.3.1. Үр ашигтай жижиг дунд үйлдвэрлэлийг орон нутгийн бодлогоор дэмжиж, 5000–аас доошгүй ажлын байр шинээр бий болгож, өрх бүрээс 1 хүнийг тогтвортой ажлын байртай байлгах бодлого хэрэгжүүлнэ.

2.3.2. Иргэдээ ажилтай, орлоготой, өрхийг өсөлттэй болгох замаар ажилгүйдлийн түвшинг 3 хувьд , ядуурлын хамрах хүрээг нэг оронтой тоонд хүргэж бууруулна.

/2018 оны байдлаар манай аймгийн ажилгүйдлийн түвшин 7,3 хувьтай болж өмнөх оныхоосоо өссөн, ядуурлын хамрах хүрээ 29,6 хувийн үзүүлэлттэй байна./

2.3.3. Өрхийн үйлдвэрлэлийн өсөлтийг бүх талаар дэмжиж, бага оврын дэвшилтэт тоног төхөөрөмжийн мэдээллийг иргэдэд хүргэх, зуучлах, тоног төхөөрөмжийг түрээслэх, лизингийн зээлээр олгох үйлчилгээг хөгжүүлнэ.

2.3.4. Шинээр ажлын байр бий болгож нутгийн иргэдийг тогтвортой ажлын байраар хангасан ААН-үүдийг жил бүр шалгаруулж, тэдний үйл ажиллагааг дэмжиж урамшуулдаг тогтолцоог бий болгоно.

### **2.4.Нийгмийн хамгаалал.**

2.4.1. Зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, тэдэнд чиглэсэн төрийн халамжийн бодлогыг хүртээмжтэй хүргэхийн зэрэгцээ тэдний ажил хөдөлмөр эрхлэх идэвхи санаачилга, боломжийг дэмжиж, хөгжүүлнэ.

The bottom right of the page features two handwritten signatures in black ink. Below the signatures is a red rectangular stamp containing the number "000000003".

2.4.2. Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “хөгжлийн төв”-ийг түшиглэн тэдэнд хөдөлмөр эрхлэх дэд бүтэц, техник, тоног төхөөрөмжийн таатай орчинг бүрдүүлнэ.

2.4.3. Ахмадын болон зорилтот бүлгийн иргэдийн сувилал, сэргээн засах эмчилгээг дэмжиж ажиллахын зэрэгцээ ахмадын, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдөр өнжүүлэх үйлчилгээг бий болгоно.

2.4.4. Аймгийнхаа хүн амын эрүүл амьдрах, урт удаан наслах нөхцөлийг бүх талаар хангаж, дундаж наслалтыг аймгийн /2016-2025 он/ хөгжлийн бодлогын баримт бичигт заасан түвшинд хүргэнэ. /2018 оны статистик мэдээгээр манай аймгийн хүн амын дундаж наслалт 70.01 байна./

2.4.5. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тэднийг бүх талаар дэмжиж ажиллана.

## Гурав. Эзэн Баянхонгорчууд

### 3.1. Өрхийн өсөлтийг тэтгэсэн Хөдөө аж ахуй

Аймгийнхаа ХАА-н салбарт мах, сүү, төмс, хүнсний ногооны чиглэлээр кластер хөгжүүлж, боловсруулалт, үйлдвэрлэл, тээвэр ложистикийн менежментийг хамтад нь шийдвэрлэнэ. Мал сүргийг чанаржуулж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлж, малынхаа тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах бодлогыг баримтална.

#### 3.1.1. Мал аж ахуй

1. Аймгийн төвөөс 50 км-ийн тойрогт /Өлзийт, Баян-Овоо, Эрдэнэцогт/ мах, сүүний чиглэлийн өндөр ашиг шимтэй “эрчимжсэн үхрийн аж ахуй”-г хөгжүүлж, үржүүлнэ.

2. Одоогийн мах боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж, “бүсүүдийн төвийн зарим сумдад махны жижиг оврын үйлдвэр” байгуулан, орчин үеийн дэвшилтэт технологи, олон улсын стандартын шаардлагад нийцсэн махан бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргана.

3. Говийн бүсийн сумдад ингэ, ямааны сүү, Хангайн бүсийн сумдад сарлагийн сүүг уламжлалт болон орчин үеийн технологиор боловсруулах жижиг дунд үйлдвэрүүдийг байгуулан хөгжүүлнэ.

4. Тал хээрийн болон говийн бүсийн сумдын хонин сүрэгт Баяд, Барга үүлдрийг, Жаргалантын бүсэд Байдраг үүлдрийг үндсэн сайжруулагчаар ашиглаж, 1 хонин толгойн амьдын жин, махны гарцыг нэмэгдүүлнэ.

5. Тал хээрийн бүсэд мах, сүүний чиглэлийн өндөр ашиг шимтэй үхэр үржүүлэх, “үхэржүүлэх” бодлого хэрэгжүүлнэ.

6. “Малын эрсдлийн сан”-г сум бүрт байгуулан малын эрүүл мэндийг хамгаалах, үүлдэр угсааг сайжруулах, бэлчээрийг усжуулах арга хэмжээг тухайн сангийн хөрөнгөөр шийддэг байх орчинг бүрдүүлнэ.





7. Бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлж, энэ чиглэлээр малчдын бүлэг, нөхөрлөлийн санаачилгыг дэмжинэ.

8. Гахай, тахиа, загас үржүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.



### 3.1.2. Газар тариалан:

1. Аймгийн хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрийн аймгийн хөрсөнд тариалсан бүтээгдэхүүнээр 100 хувь хангах асуудлыг бүрэн шийдвэрлэж, төмс, хүнсний ногооны тариалалт, хураан авалт, хадгалалт, борлуулалтын кластрын сүлжээг бий болгоно.

2. “Алим”, “Сонгино”, “Саримс” аймгийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, нарийн ногооны үрийн аж ахуй байгуулах санаачилгыг дэмжинэ.

3. Төмс, хүнсний ногооны аймгийн дотоодын хэрэгцээгээ хангах зорилтын хүрээнд сум бүрт 100тн хүртэл багтаамжтай, аймгийн төвд 4000тн хүртэл багтаамжтай стандарт зоориудыг барьж ашиглах асуудлыг шийдвэрлэнэ.

4. Хүлэмжийн аж ахуйг боломжит сумдад хөгжүүлэхийн зэрэгцээ Баянхонгор, Шаргалжуутыг түшиглэн 4 улирлын ажиллагаатай хүлэмжийн тариалан хөгжүүлнэ.

5. Жил бүр мал аж ахуйн салбарын өвөлжилт хаваржилтын нөөцийн хадлан тэжээлийг бэлтгэж, аймгийн хэрэгцээгээ хангадаг болно.

6. Тариалангийн бүсүүдэд байгаа инженерийн хийцтэй услалтын системүүдийг бүрэн ашигладаг болох.

### 3.2. Тогтвортой байгаль орчин

3.2.1. Байгаль орчинд ээлтэй утаагүй эко түлшээр орон нутгийн болон аймгийн төвийн түлшний хэрэгцээг хангах, хийн болон цахилгаан халаагуурын ашиглалтыг нэмэгдүүлэх замаар аймгийн төвийн утааг 80 хувь бууруулна.

3.2.2. Газар зохион байгуулалтын төлөвлөлтөд тусгах замаар төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг одоогийн түвшингээс 10 дахин нэмэгдүүлж, эвдэрсэн газруудыг бүрэн нөхөн сэргээх ажлыг оновчтой зохион байгуулна.

3.2.3. Сумдад хог хаягдлыг ангилан ялгах ажлыг зохион байгуулж, хогийн цэгийг ландфилын аргаар дарж, Баянхонгор суманд хог хаягдлыг дахин боловсруулах жижиг үйлдвэр байгуулах


3.2.4. Гол горхи, булаг шандны эх болон цөлжилт, хөрсний элэгдэлд орсон газруудад заг, сухай, хайлаас, буйлс зэрэг модлог ургамлуудыг тариалж, ногоон зурвас бий болгох, Түй, Байдраг, Шаргалжуут, Цагаан туруут зэрэг томоохон голуудын ай сав газарт мод тариалж аймгийн ойн сангийн хэмжээг нэмэгдүүлэх.

3.2.5. Байгаль орчноо нөхөн сэргээх, ногооруулах бодлогын хүрээнд “Нэг сая мод” дэд хөтөлбөр хэрэгжүүлж, мод тарих санал, санаачилгыг бүх талаар дэмжинэ.

3.2.6. Аймгийн төвийг тойрсон ойн зурвасыг арчилж, сэргээн хамгаалж ургуулахын зэрэгцээ сум суурингуудыг ногоон зурвастай болгоно.

**Дөрөв. Хуулиа дээдэлдэг, иргэддээ үйлчилдэг засаглал**

#### 4.1. Сайн засаглал

  
000000005

4.1.1. Засаг захиргааны бүх шатанд хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэх чадвартай, авилгаас ангид байж, иргэндээ чанартай үйлчилгээ үзүүлдэг, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай Ухаалаг ардчилсан засаглалыг төлөвшүүлнэ.

4.1.2. Төрийн бүх байгууллагуудад орон тоо гарсан нөхцөлд олон нийт, хамт олны оролцоог хангасан, мэдлэг ур чадварт суурилсан нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгодог тогтолцоог хэлбэрэлтгүй дагаж мөрдөнө.

4.1.3. Төрийн албан тушаалтантай холбоотой авлига, ашиг сонирхол, ёс зүйн зөрчлийн талаар гаргасан иргэдийн мэдээллийг хүлээн авах цахим орчныг бүрдүүлж, түүний нууцыг хадгалж, мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийж, хариуцлага тооцох зарчмыг нэвтрүүлнэ.

4.1.4. Төрийн албан хаагчдын архидалтыг таслан зогсоож, төрийн албыг архинаас ангид байлгана.

#### **4.2. Төсөв санхүү**

4.2.1. Төсвийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтаар орон нутгийн ААН, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.

4.2.2. Төсвийн зардлыг ач холбогдолоор нь эрэмбэлэх зарчимд шилжиж, алдагдлыг багасган хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж, аймгийн төсвийн чадавхийг нэмэгдүүлнэ.

4.2.3. Төсвийн ил тод байдлыг хангах шаардлагын дагуу Шилэн дансанд мэдээллийг тогтмол байршуулж, ил тод хяналттай төсвийг бий болгоно.

4.2.4. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, салбар компаниудыг орон нутгийн татварын албанд бүртгэлтэй болгож, татварын орлогыг нэмэгдүүлэх

#### **4.3. Дэд бүтэц, хот байгуулалт, сум багийн хөгжил.**

4.3.1. Баянхонгор хотын цэвэр усны шугамын шаардлагатай хэсгүүдийг шинэчилж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн стандарт шугамтай болгоно.

4.3.2. Ипотекийн зээлийн бодлоготой уялдуудан сум бүрт дэд бүтцийг нь бүрэн шийдсэн 30-50 айлын хувийн хаус хороолол, аймгийн төвд 200 айлын хаус хороолол, 1000 хүртэл айлын орон сууц шинээр ашиглалтад оруулна. Энэ бодлогыг хэрэгжүүлэхдээ МСҮТ-ийн төгсөгчдийг ажлын байраар хангах асуудлыг давхар шийдвэрлэнэ.

4.3.3. Баянхонгор хот, хөдөөгийн сумын төвийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд "Шинэ гудамж", "Ногоон хороолол" төсөл хэрэгжүүлж, өрх бүр хашаандаа мод, хүнсний ногоо тариалж, орчноо ногооруулж, жишиг гудамж бүхий ногоон суурингуудыг бий болгоно.

4.3.4. Сум, багийн төвүүдийг шинэчлэх төслийг сэргээн хэрэгжүүлж, ногоон байгууламж, хот тохижилтын чиглэлийн хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжиж хамтран ажиллана.

4.3.5. Засгийн газраас хэрэгжүүлэх орон нутгийн автозамын сүлжээнд сумдыг хамруулах ажлыг эхлүүлнэ.

4.3.6. Эмч, багш нар болон төрийн албан хаагчдыг орон сууцжуулах бодлогын хүрээнд хувийн хэвшлийнхэнтэй хамтран ажиллана.



Handwritten signatures and a red stamp.



## Тав. Аюулгүй, амгалан Баянхонгорчууд

### 5.1. Гэмт хэрэг зөрчлийг бууруулах

5.1.1. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж, төв суурин газар, тодорхой цэгүүдийг телекамерийн хяналтад авах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

5.1.2. Архины хор уршгийг тайлбарлан таниулж, гэгээрүүлэх замаар “Архигүй Баянхонгорчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.1.3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд эрчимжүүлж “Малын хулгайгүй аймаг” болохыг зорино.

5.1.4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад анхаарч, хот хооронд, сум хоорондын зорчигч тээврийн замд хяналтын цэг /пост/-уудыг тогтмол хариуцлагатай ажиллуулан, энэ төрлийн гэмт хэрэг, ослын тоог 2 дахин бууруулна.

### 5.2. Аялал жуулчлал, гадаад харилцаа.

5.2.1. Аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг тодотгож хэрэгжүүлнэ.

5.2.2. Гадаад дотоодын жуулчдад мэдээлэл хүргэх, зуучлах тур операторуудын үйл ажиллагааг дэмжиж, хөгжүүлнэ.

5.2.3. Нүүдлийн МАА-н соёл иргэншилд суурилсан нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг бодлогоор дэмжиж ажиллана.

5.2.4. “Баянхонгорын бүтээгдэхүүн борлуулах цэг”-үүдийг ӨМӨЗО-ны Эрээн хот, Эзиний хошуудад нээж, тогтмол ажиллуулах.

5.2.5. Хөрш орнуудтай харилцан хамтын ажиллагаагаа өргөжүүлж, бизнес аялал, хилийн болон гадаад худалдааг жилд 2 удаа зохион байгуулж, малчид үйлдвэрлэл эрхлэгчдийг өргөнөөр оролцуулна.

5.2.6. Аймгийн эдийн засгийн гадаад хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлж, Япон, Солонгос, БНХАУ зэрэг улс орнуудтай бизнес, үйлдвэрлэлийн чиглэлээр хамтран ажиллана.

БАЯНХОНГОР АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМ

The image shows two handwritten signatures in black ink. Below the signatures is a red rectangular stamp containing a series of numbers: 0000000001.